

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

| | |
|--|----|
| 1. Аудитын гэрчилгээ | 2 |
| 2. Аудитын тайлан..... | 4 |
| 2.1. Оршил | 4 |
| 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага | 4 |
| 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт..... | 4 |
| 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин | 5 |
| 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ | 5 |
| 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал | 5 |
| 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар | 6 |
| 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд | 6 |
| 2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга..... | 7 |
| 2.10 Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн | 8 |
| 2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал | 8 |
| 2.10. Шилэн дансны мэдээлэл | 8 |
| 2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга | 8 |
| 2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл | 8 |
| 3. Менежментийн захидал | 9 |
| 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан..... | 12 |
| 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан | 12 |
| 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан | 14 |
| 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан..... | 16 |
| 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан | 18 |
| 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан | 19 |
| 5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт | 22 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| БШУС | Боловсрол Шинжлэх Ухаан Спорт |
| БСШУСС | Боловсрол Соёл Шинжлэх Ухаан Спортын Сайд |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.02.21 № 06/557
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол Улсын Консерваторийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол Улсын Консерваторийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монгол Улсын Консерваторийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Монгол Улсын Консерваторийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Монгол Улсын Консерваторийн захирлын үүрэг гүйцэтгэгч Ц.Пүрэвхүү танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн шинэчлэх, тээвэр шатахууны зардлын зарцуулалтын талаар, ашиглалтгүй хөрөнгийг данснаас хасах, өр төлбөр үүсгэхгүй байх талаархи зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол Улсын Консерваторийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монгол Улсын Консерваторийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 12 дугаар сарын 16-наас 2020 оны 02 дугаар сарын 17-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын захиалгаар Юнистар Аудит ХХК-ын аудитын баг хариуцаж хэрэгжүүлэв.

Монгол Улсын Консерваторийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 52 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Монгол Улсын Консерваторийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь тогтвортой хөгжих нөхцөлийг хангасан Зүүн хойд Азийн тэргүүлэх Консерваториудын нэг болоход оршино.

Үйл ажиллагааны чиглэл:

БШУС-ын 2014 оны А/78, БСШУСС-ын 2017 оны А/84 дүгээр тушаалаар Монгол Улсын Консерваторийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монгол Улсын Консерватори нь Монгол Улсын мэргэжлийн урлагийн байгууллага бөгөөд сургалтын нийтлэг шаардлага, нийгмийн эрэлтэд нийцсэн бүрэн дунд, мэргэжлийн, бакалавр, магистр, докторын боловсролтой чадварлаг мэргэжилтэнг бэлтгэх үндсэн чиг үүрэгтэй байгууллага юм.
- Монгол Улсын урлагийн салбарын хөгжил дэвшилд чиглэсэн эрдэм мэдлэг, соёлыг түгээх, шинжлэх ухааны үндэслэлтэй бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцох.
- Шинжлэх Ухааны судалгаа хийх, шинэ уран бүтээл, шинэ мэдлэг бүтээж, сургалт судалгаанд нэвтрүүлэх, инновацын бодлого хэрэгжүүлэх.
- Үндэсний сэтгэлгээ, урлаг, өв санг бэхжүүлэх хүрээнд Монголын урлаг судлал, дэлхийн урлагийн өв сангаас гүнзгийрүүлэн судалж, эзэмших хүрээнд “Зэрэгцүүлсэн болон харьцуулсан урлаг судлал”-ыг хөгжүүлэх.
- Монгол улсын урлагийн салбарын мэргэжилтний давтан сургалт, мэргэжил дээшлүүлэх, урт богино хугацааны сургалтыг чанартай гүйцэтгэж, хүний нөөцийн бодлого боловсруулах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Монгол Улсын Консерваторийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамтай нийцээгүй байна.

Монгол Улсын Консерватори нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Ординат ХХК-ийн Юникус санхүүгийн программ хангамж ашигладаг байна.

Монгол Улсын Консерваторийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Монгол Улсын Консерваторийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо

олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 17 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын дүнг сонгож, эрсдэлийн түвшинг бага гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 3,986,716.3 мянган төгрөгөөс тооцон 39,867.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлт болон түвшинг өөрчлөөгүй бөгөөд 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын дүнгийн 1%-иар буюу 45,276.2 мянган төгрөгөөр тооцсон.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Монгол Улсын Консерваторийн 2019 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 347,159.3 мянган төгрөгөөр буюу 2.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, бараа материалын дансны үлдэгдэл нэмэгдэж, үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---------------------|---------------------|--------------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 334.9 | 2,588.5 | 2,253.6 |
| Бусад төсөл, нөөцийн харилцах | 334.9 | 2,588.5 | 2,253.6 |
| Бараа материал | 140,741.6 | 168,101.6 | 27,360.0 |
| Үндсэн хөрөнгө | 11,632,587.1 | 11,255,814.2 | (376,772.9) |
| Нийт хөрөнгө | 11,773,663.6 | 11,426,504.3 | (347,159.3) |
| Өр төлбөр | 539.9 | 671.4 | 131.5 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 11,773,123.7 | 11,425,832.9 | (347,290.8) |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 11,773,663.6 | 11,426,504.3 | (347,159.3) |

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь хангамжийн материал буюу дотуур байрны хүүхдийн зөөлөн эдлэл, хүүхдийн түрээсийн сурах бичгийн үлдэгдэл өссөнөөс шалтгаалжээ. БСШУСС-ын 2019 оны А/302 тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад сурах бичиг төлбөртэй ашиглуулах үйлчилгээний журам”-ын 2 дугаар зүйлийн 2.3.1-д “...эргэлтийн хөрөнгийн дансанд бүртгэнэ” гэсэн заалтын дагуу бараа материал дансанд бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгийн дүн 71,842.1 мянган төгрөгийн худалдан авалт, 39,468.9 мянган төгрөгийн хандивын хөрөнгийн дүнгээр нэмэгдэж 488,083.9 мянган төгрөгийн элэгдлийн зардлын дүн болон акталсан хөрөнгийн дүнгээр буурсан байна.

Биет бус хөрөнгийн дүн нь тайлант онд 1,430.0 мянган төгрөгийн нярвын програм авсан дүнгээр өсөж тайлант үеийн 2,056.7 мянган төгрөгийн элэгдлийн зардлын дүнгээр буурсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл нь тайлант хугацаанд цалингаас суутгасан байгууллагын үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн татвар, хувь хүнээр хийлгэсэн ажил үйлчилгээний хөлснөөс суутгасан татварын үлдэгдлээр өссөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 11,425,832.9 мянган төгрөг болж тайлант хугацаанд 347,290.8 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Монгол Улсын Консерваторийн тайлант онд 408,972.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 428,570.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 4.8 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Өөрийн орлого

/мянган төгрөг/

| Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|-------------------------------|------------------|------------------|-----------------|------------|
| Үндсэн үйл ажиллагааны орлого | 386,472.0 | 405,967.7 | 19,495.7 | 5.0 |
| Туслах үйл ажиллагааны орлого | 22,500.0 | 22,603.0 | 103.0 | 0.5 |
| Нийт дүн | 408,972.0 | 428,570.7 | 19,598.7 | 4.8 |

Өөрийн орлого 19,597.8 мянган төгрөгөөр давсан нь 2019-2020 оны хичээлийн жилд магистрийн сургалтанд гадаад дотоодын 56 оюутан, дуулаачаар бэлтгэгдэх 53 оюутан, нийт 106 оюутан суралцагчдыг элсүүлж 108,812.5 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж сургалтын үйл ажиллагаа өргөжсөнтэй холбоотой байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх ерөнхий боловсрол болон үндсэн үйл ажиллагааны хөтөлбөрт зориулан 4,327,498.1 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас нийт зардлын 3,918,526.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 408,972.0 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн зардал 4,327,498.1 мянган төгрөгөөр батлагдсан бөгөөд зардлын нийт гүйцэтгэл 4,316,326.0 мянган төгрөг буюу 99.7 хувьтай байна. Төсвийн зардал нь эдийн засгийн ангилал, бүлгийн дүнгээр хэтрээгүй бөгөөд цалин, нийгмийн даатгалын зардал, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлаар хэмнэсэн байна.

Нэмэлт төсөв: Дээд шатны төсвийн захирагчаас 11,086.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 112,704.0 мянган төгрөг, нийт 123,790.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс Цалин хөлс болон урамшуулалд 4,800.0 мянган төгрөг, байрны түрээст 5,814.0 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 58,569.2 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжид 28,000.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 22,600.0 мянган төгрөг, тэтгэмж урамшууллын зардалд 3,586.0 мянган төгрөг нийт 123,369.2 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 420.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2.10 Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд 17 эрсдэл тодорхойлж, гүйцэтгэх үе шатанд 17 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 1,933.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 1,933.9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгч менежментийн захидалд тусгалаа.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх болон анхаарал татахуйц асуудал ажиглагдаагүй.

2.10. Шилэн дансны мэдээлэл

Монгол Улсын Консерватори нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг 2019 онд 102 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 3 мэдээллийг байршуулаагүй байна. Үүнд:

Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрт 1 удаа, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 1 удаа тус тус хугацаа хоцроож мэдээлсэн байна, Байршуулаагүй мэдээлэл нь 4 дүгээр сард мэдээлэх үүрэгтэй байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 979.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 зөвлөмж өгснөөс зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Балансын данстай холбоотой үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох болон няравын програмтай болох талаар зөвлөмж өгсөн бөгөөд зөвлөмжийн биелэлт 100 хувьтай байна.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Монгол Улсын Консерваторийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй 1,933.9 мянган төгрөгийн алдаа зөрчил нь бидний тооцсон 45,276.2 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй дүгнэлт өгч байна.

“Зөрчилгүй дүгнэлт”

Монгол Улсын Консерваторийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дүгээр хэсгийн 4.1.3 заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

3.1.1 Илрүүлэлт:

Тээвэр шатахууны нормативт зардлыг батлагдсан төсөвтэй харьцуулахад зардал 562.5 мянган төгрөг хэтэрсэн боловч тус зардлын тооцооллыг хийж батлагдсан нормативт зардлын төсөвтэй харьцуулахад хэтрээгүй байна. Харин сургуулийн аж ахуйн хэрэгцээнд бараа материал, сурагчдын сурах бичиг татан авах, хөгжим техник хэрэгсэл зөөх, оюутан, сурагчид болон багш нарыг төрийн ёслолын үйл ажиллагаа /чингис хаан одон гардуулах гэх мэт/, улсын баяр наадмын арга хэмжээ, телевиз, радиод уран бүтээлийн бичлэг хийлгэх, Монгол Улсын Засгийн газрын соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэн орон нутгийн иргэдэд урлагийн тоглолтоор үйлчлэх гэх мэт зайлшгүй ажлын шаардлага гарсан үед машин хөлслөхөд гарсан зардлаар хэтэрсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Тээвэр шатахуун, нормативт зардлыг батлагдсан төсвөөс үндэслэлгүй хэтрүүлэн зарцуулсан байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, төсвийн дагуу зарцуулах;

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Төсвийн дагуу зарцуулна.

3.2 Балансын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Тайлант онд 671.4 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн байна. Энэ нь татварын байгууллагад өгөх хувь хүнээс суутгасан орлогын албан татварын тооцоо болон сургуулийн үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн тооцоог хийгээгүйгээс үүссэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг мөрдөөгүй, эрх ба үүрэг, хэмжилт гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Өр төлбөрийг барагдуулаагүй.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийг зохистой удирдаж өр төлбөр үүсгэхгүй байх.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.3 Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

3.3.1 Илрүүлэлт:

Тус байгууллага нь БСШУСЯ-ны 2017 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/40 дүгээр тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогийн баримт бичгийг мөрддөг. Энэ нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан дүрэм журам нь хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомж, стандарт, дүрэм журам, заавартай нийцэхгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалттай нийцэхгүй, үнэлгээ, хэмжилт гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.3.2 Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь тухайн байгууллагын онцлог, үйл ажиллагаатай уялдаагүй байх.

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг боловсруулж, баталж, дагаж мөрдөх.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг боловсруулж, баталж, дагаж мөрдөн ажиллана.

3.4 Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

3.4.1 Илрүүлэлт:

Ординат ХХК-ийн Виница программ нь анхны өртгөө элэгдлээрээ нөхсөн зөвхөн үлдэгдэл, мэдээлэл харах зорилготой санхүүгийн программ байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал, толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.4.2 Эрсдэл:

Ашиглалтгүй биет бус хөрөнгийг нягтлан бүртгэл, тайлангаас хасаагүй байх.

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Ашиглалтгүй байгаа санхүүгийн програмыг зохих дээд байгууллагын шийдвэрийг гаргуулж биет бус хөрөнгөнөөс хасах.

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүсэлтээ явуулж актална.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------------|------------------------------------|--------------------------|--------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 141,076,526.90 | 170,690,096.90 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 334,920.00 | 2,588,500.00 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 334,920.00 | 2,588,500.00 |
| 3121 | Төгрөг | 334,920.00 | 2,588,500.00 |
| 31214 | Бусад төсөл, нөөцийн харилцах | 334,920.00 | 2,588,500.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 140,741,606.90 | 168,101,596.90 |
| 351 | Түүхий эд материал | 16,435,394.00 | 16,465,085.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 16,285,394.00 | 16,285,394.00 |
| 35130 | Эм боох материал | 150,000.00 | 179,691.00 |
| 354 | Хангамжийн материал | 124,306,212.90 | 151,636,511.90 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 4,543,900.00 | 5,929,100.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 110,947,427.90 | 110,994,537.90 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | - | 43,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 26,180.00 | 26,180.00 |
| 35450 | Барилгын засварын материал | - | 756,300.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 8,788,705.00 | 33,887,394.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 11,632,587,097.13 | 11,255,814,212.11 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 11,632,587,097.13 | 11,255,814,212.11 |
| 391 | Газар | | |
| 392 | Биет хөрөнгө | 10,796,238,697.17 | 10,420,092,478.91 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 9,503,526,410.85 | 9,503,526,410.85 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | - | -276,073,912.44 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 25,700,000.00 | 47,400,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -23,219,999.68 | -11,159,999.64 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 2,058,060,609.30 | 2,083,903,679.35 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -1,119,219,384.29 | -1,250,731,714.38 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 717,746,770.86 | 709,654,747.31 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -494,379,807.19 | -518,036,449.42 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 22,952,942.40 | 22,952,942.40 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -21,864,942.40 | -21,941,942.44 |
| 39217 | Ном | 126,936,097.32 | 130,598,717.32 |
| 393 | Биет бус хөрөнгө | 836,348,399.96 | 835,721,733.20 |
| 39301 | Програм хангамж | 15,334,000.00 | 16,764,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -4,028,000.04 | -6,084,666.80 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 825,042,400.00 | 825,042,400.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 11,773,663,624.03 | 11,426,504,309.01 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 539,900.00 | 671,422.85 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 539,900.00 | 671,422.85 |
| 413 | Өглөг | 539,900.00 | 671,422.85 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 470,172.85 |

Монгол Улсын Консерваторийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | |
|-------------|---|--------------------------|--------------------------|
| 4136 | Бусад өглөг | 539,900.00 | 201,250.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 539,900.00 | 201,250.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 11,773,123,724.03 | 11,425,832,886.16 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 11,773,123,724.03 | 11,425,832,886.16 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 8,010,432,655.62 | 8,010,432,655.62 |
| 51106 | Эздийн өмчийн бусад хэсэг | 8,010,432,655.62 | 8,010,432,655.62 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | -1,362,871,819.50 | -1,710,162,657.37 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -1,362,871,819.50 | -1,362,871,819.50 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | -347,290,837.87 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 5,125,562,887.91 | 5,125,562,887.91 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 11,773,663,624.03 | 11,426,504,309.01 |

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|-------------|--|-------------------------|-------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 3,853,306,592.85 | 4,527,623,724.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 470,351,130.85 | 485,307,624.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 460,510,540.00 | 445,838,724.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 460,510,540.00 | 445,838,724.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 409,169,851.00 | 408,221,285.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 29,632,825.00 | 22,603,050.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 21,707,864.00 | 15,014,389.00 |
| 122 | Тусламжийн орлого | 9,840,590.85 | 39,468,900.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 9,840,590.85 | 39,468,900.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 3,382,955,462.00 | 4,042,316,100.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 3,318,152,920.00 | 3,918,526,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 3,317,818,000.00 | 3,918,526,100.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 334,920.00 | |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 64,802,542.00 | 123,790,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 64,802,542.00 | 11,086,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 112,704,000.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 4,127,849,173.72 | 4,874,914,561.87 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 4,127,849,173.72 | 4,874,914,561.87 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 3,914,536,677.99 | 4,674,599,079.19 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 2,675,185,082.09 | 3,197,504,972.09 |
| 210101 | Үндсэн цалин | 2,675,185,082.09 | 1,635,490,247.16 |
| 210102 | Нэмэгдэл | - | 1,477,960,924.93 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 84,053,800.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 310,190,235.33 | 390,978,801.09 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 265,345,637.02 | 276,065,319.37 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | - | 26,285,476.39 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | - | 32,020,846.06 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | - | 5,017,793.86 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 44,844,598.31 | 51,589,365.41 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 296,570,906.85 | 303,673,660.99 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 49,842,050.00 | 55,051,505.00 |
| 210302 | Түлш, халаалт | 77,303,860.00 | 80,888,670.26 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 19,424,996.85 | 27,733,485.73 |
| 210304 | Байрны түрээс | 150,000,000.00 | 140,000,000.00 |
| 210305 | Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/ | | |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 75,647,490.42 | 54,918,652.00 |

Монгол Улсын Консерваторийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | |
|-------------|--|------------------------|------------------------|
| 210401 | Бичиг хэрэг | 11,659,010.00 | 11,826,380.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,666,430.00 | 2,230,136.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 9,044,500.00 | 7,183,900.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,314,800.00 | 560,200.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,412,000.00 | 3,244,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 50,152,590.42 | 5,827,030.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 398,160.00 | 24,046,606.00 |
| 2105 | Нормативт зардал | 39,089,743.00 | 47,803,844.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 197,800.00 | 115,644.00 |
| 210502 | Хоол, хүнс | 38,891,943.00 | 47,688,200.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | | |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 54,113,630.00 | 9,004,200.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,810,000.00 | 200,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 52,303,630.00 | 8,804,200.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 87,459,918.00 | 123,217,280.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 76,964,118.00 | 103,247,200.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 10,000,000.00 | 5,500,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 198,800.00 | 234,580.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 297,000.00 | 14,235,500.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 376,279,672.30 | 547,497,669.02 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,839,411.00 | 5,274,100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 58,851,479.00 | 54,139,674.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 304,588,782.30 | 488,083,895.02 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 213,312,495.73 | 200,315,482.68 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 158,142,414.00 | 169,123,812.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 24,674,200.00 | 29,731,200.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 133,468,214.00 | 133,986,612.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 5,406,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 55,170,081.73 | 30,770,850.68 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 55,170,081.73 | 30,770,850.68 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | 420,820.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 420,820.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | -274,542,580.87 | -347,290,837.87 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | -274,542,580.87 | -347,290,837.87 |

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|--|------------------|------------------|
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 3,821,758,138.00 | 4,473,140,435.00 |
| ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 438,802,676.00 | 430,824,335.00 |
| Нийтлэг татварын бус орлого | 438,802,676.00 | 430,824,335.00 |
| Төсөв байгууллагын өөрийн орлого | 438,802,676.00 | 430,824,335.00 |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 409,169,851.00 | 408,221,285.00 |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 29,632,825.00 | 22,603,050.00 |
| ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 3,382,955,462.00 | 4,042,316,100.00 |
| Улсын төвлөрсөн төсвөөс | 3,318,152,920.00 | 3,918,526,100.00 |
| Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 3,317,818,000.00 | 3,918,526,100.00 |
| Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 334,920.00 | 0.00 |
| Нэмэлт санхүүжилтийн орлого | 64,802,542.00 | 123,790,000.00 |
| Нэмэлт санхүүжилт | 64,802,542.00 | 11,086,000.00 |
| Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 0.00 | 112,704,000.00 |
| НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 3,796,799,118.00 | 4,399,044,745.00 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 3,796,799,118.00 | 4,399,044,745.00 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 3,583,486,622.27 | 4,198,729,262.32 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал | 2,674,645,182.09 | 3,197,034,799.24 |
| Үндсэн цалин | 1,931,063,960.48 | 2,282,259,900.00 |
| Нэмэгдэл | 643,391,221.61 | 809,784,899.24 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 80,190,000.00 | 80,190,000.00 |
| Урамшуулал | 20,000,000.00 | 24,800,000.00 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 310,190,235.33 | 390,978,801.09 |
| Тэтгэврийн даатгал | 310,190,235.33 | 390,978,801.09 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 296,570,906.85 | 303,673,660.99 |
| Гэрэл, цахилгаан | 49,842,050.00 | 55,051,505.00 |
| Түлш, халаалт | 77,303,860.00 | 80,888,670.26 |
| Цэвэр, бохир ус | 19,424,996.85 | 27,733,485.73 |
| Байрны түрээс | 150,000,000.00 | 140,000,000.00 |
| Хангамж, бараа материалын зардал | 29,863,228.00 | 31,269,916.00 |
| Бичиг хэрэг | 7,064,210.00 | 10,501,980.00 |
| Тээвэр, шатахуун | 1,692,610.00 | 2,230,136.00 |
| Шуудан, холбоо, интернетийн төлбөр | 8,923,000.00 | 7,723,800.00 |
| Ном, хэвлэл | 555,600.00 | 569,950.00 |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,412,000.00 | 3,244,400.00 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 10,215,808.00 | 6,999,650.00 |
| Нормативт зардал | 40,082,943.00 | 57,774,535.00 |
| Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 150,000.00 | 145,335.00 |
| Хоол, хүнс | 38,891,943.00 | 47,688,200.00 |
| Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,041,000.00 | 9,941,000.00 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 45,554,088.00 | 25,293,696.00 |

Монгол Улсын Консерваторийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | |
|--|----------------|----------------|
| Багаж, техник, хэрэгсэл | 7,373,600.00 | 293,700.00 |
| Урсгал засвар | 38,180,488.00 | 24,999,996.00 |
| Томилолт, зочны зардал | 759,900.00 | 0.00 |
| Гадаад албан томилолт | 0.00 | 0.00 |
| Дотоод албан томилолт | 759,900.00 | 0.00 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 112,462,836.00 | 128,740,980.00 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 101,967,036.00 | 107,539,500.00 |
| Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 10,000,000.00 | 5,500,000.00 |
| Тээврийн хэрэгслийн татвар | 198,800.00 | 331,480.00 |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 297,000.00 | 15,370,000.00 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 73,357,303.00 | 63,962,874.00 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 12,888,691.00 | 6,462,900.00 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 60,468,612.00 | 57,499,974.00 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 213,312,495.73 | 200,315,482.68 |
| Бусад урсгал шилжүүлэг | 158,142,414.00 | 169,123,812.00 |
| Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамгуулал | 24,674,200.00 | 29,731,200.00 |
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 133,468,214.00 | 133,986,612.00 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 0.00 | 5,406,000.00 |
| Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 55,170,081.73 | 30,770,850.68 |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | 55,170,081.73 | 30,770,850.68 |
| Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 0.00 | 420,820.00 |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | 0.00 | 420,820.00 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 24,959,020.00 | 74,095,690.00 |
| ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН | 24,624,100.00 | 71,842,110.00 |
| ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 24,624,100.00 | 71,842,110.00 |
| Дотоод эх үүсвэрээр | 24,624,100.00 | 71,842,110.00 |
| Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 24,624,100.00 | 71,842,110.00 |
| ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | -24,624,100.00 | -71,842,110.00 |
| НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 334,920.00 | 2,253,580.00 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 334,920.00 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 334,920.00 | 2,588,500.00 |

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|--|---------------------------------|-------------------------|--------------------------|--|
| 2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 7,185,390,255.62 | 191,859,293.04 | -1,275,808,134.95 | 6,101,441,413.71 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 825,042,400.00 | 0.00 | 0.00 | 825,042,400.00 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 8,010,432,655.62 | 191,859,293.04 | -1,275,808,134.95 | 6,926,483,813.71 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 0.00 | 4,933,703,594.87 | 0.00 | 4,933,703,594.87 |
| Тайлант үеийн үр дүн | | | -87,063,684.55 | -87,063,684.55 |
| 2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 8,010,432,655.62 | 5,125,562,887.91 | -1,362,871,819.50 | 11,773,123,724.03 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 8,010,432,655.62 | 5,125,562,887.91 | -1,362,871,819.50 | 11,773,123,724.03 |
| Тайлант үеийн үр дүн | | | -347,290,837.87 | -347,290,837.87 |
| 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 8,010,432,655.62 | 5,125,562,887.91 | -1,710,162,657.37 | 11,425,832,886.16 |

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| № | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|--------|--|-------------------------|-------------------------|----------------------|-------------|
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 4,327,498,100.00 | 4,316,326,004.32 | 11,172,095.68 | 99.7 |
| II | НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН | 4,327,498,100.00 | 4,316,326,004.32 | 11,172,095.68 | 99.7 |
| 21 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 4,160,305,800.00 | 4,150,788,192.32 | 9,517,607.68 | 99.8 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 567,745,600.00 | 567,574,591.99 | 171,008.01 | 100.0 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл суутгал | 3,193,386,800.00 | 3,192,234,799.24 | 1,152,000.76 | 100.0 |
| 210101 | Үндсэн цалин | 2,282,259,900.00 | 2,282,259,900.00 | 0.00 | 100.0 |
| 210102 | Нэмэгдэл цалин | 810,936,900.00 | 809,784,899.24 | 1,152,000.76 | 99.9 |
| 210103 | Унаа хоолны нэмэгдэл | 80,190,000.00 | 80,190,000.00 | 0.00 | 100.0 |
| 210104 | Урамшуулал | 20,000,000.00 | 20,000,000.00 | 0.00 | 100.0 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 399,173,400.00 | 390,978,801.09 | 8,194,598.91 | 98.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 399,173,400.00 | 390,978,801.09 | 8,194,598.91 | 98.0 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 297,859,700.00 | 297,859,660.99 | 39.01 | 100.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 48,750,000.00 | 55,051,505.00 | -6,301,505.00 | 112.9 |
| 210302 | Түлш, халаалт | 79,609,700.00 | 80,888,670.26 | -1,278,970.26 | 101.6 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 19,500,000.00 | 27,733,485.73 | -8,233,485.73 | 142.2 |
| 210304 | Байрны түрээс | 150,000,000.00 | 134,186,000.00 | 15,814,000.00 | 89.5 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 34,605,700.00 | 34,603,536.00 | 2,164.00 | 100.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,104,700.00 | 10,501,980.00 | -5,397,280.00 | 205.7 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,667,600.00 | 2,230,136.00 | -562,536.00 | 133.7 |
| 210403 | Шуудан, холбоо, интернетийн төлбөр | 11,460,000.00 | 7,723,800.00 | 3,736,200.00 | 67.4 |
| 210404 | Ном, хэвлэл | 4,304,700.00 | 3,903,570.00 | 401,130.00 | 90.7 |
| 210405 | Хог, хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,600,000.00 | 3,244,400.00 | 355,600.00 | 90.1 |
| 210406 | БҮТЭЗҮЙЛС | 8,468,700.00 | 6,999,650.00 | 1,469,050.00 | 82.7 |
| 2105 | Нормативт зардал | 57,779,200.00 | 57,774,535.00 | 4,665.00 | 100.0 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 150,000.00 | 145,335.00 | 4,665.00 | 96.9 |
| 210502 | Хоол хүнс | 47,688,200.00 | 47,688,200.00 | 0.00 | 100.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 9,941,000.00 | 9,941,000.00 | 0.00 | 100.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 27,263,800.00 | 27,203,006.00 | 60,794.00 | 99.8 |
| 210601 | Багаж, техник хэрэгсэл | 2,263,800.00 | 2,203,010.00 | 60,790.00 | 97.3 |
| 210604 | Урсгал засвар | 25,000,000.00 | 24,999,996.00 | 4.00 | 100.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 103,774,300.00 | 103,670,980.00 | 103,320.00 | 99.9 |
| 210801 | Бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр | 89,075,500.00 | 89,039,500.00 | 36,000.00 | 100.0 |

Монгол Улсын Консерваторийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | | | |
|-------------|---|-------------------------|-------------------------|---------------------|--------------|
| | хураамж | | | | |
| 210802 | Аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 5,500,000.00 | 5,500,000.00 | 0.00 | 100.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 398,800.00 | 331,480.00 | 67,320.00 | 83.1 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 8,800,000.00 | 8,800,000.00 | 0.00 | 100.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 46,462,900.00 | 46,462,874.00 | 26.00 | 100.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,462,900.00 | 6,462,900.00 | 0.00 | 100.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 40,000,000.00 | 39,999,974.00 | 26.00 | 100.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 167,192,300.00 | 165,537,812.00 | 1,654,488.00 | 99.0 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 167,192,300.00 | 165,537,812.00 | 1,654,488.00 | 99.0 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 28,645,200.00 | 28,645,200.00 | 0.00 | 100.0 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 135,547,100.00 | 133,986,612.00 | 1,560,488.00 | 98.9 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,000,000.00 | 2,906,000.00 | 94,000.00 | 96.9 |
| 1 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 4,327,498,100.00 | 4,318,579,584.32 | 8,918,515.68 | 99.79 |
| 120004 1 | ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО | 386,472,000.00 | 408,221,285.00 | -21,749,285.00 | 105.6 |
| 120004 1 | Үндсэн үйл ажиллагааны орлого | 386,472,000.00 | 408,221,285.00 | -21,749,285.00 | 105.6 |
| 120004 2 | ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО | 22,500,000.00 | 22,603,050.00 | -103,050.00 | 100.5 |
| 120004 2 | Үндсэн бус үйл ажиллагааны орлого | 22,500,000.00 | 22,603,050.00 | -103,050.00 | 100.5 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 3,918,526,100.00 | 3,887,755,249.32 | 30,770,850.68 | 99.2 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 3,918,526,100.00 | 3,887,755,249.32 | 30,770,850.68 | 99.2 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ | 0.00 | 334,920.00 | -334,920.00 | 0.0 |
| 3101 | МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ | 0.00 | 2,588,500.00 | -2,588,500.00 | 0.0 |
| 9001 | Удирдах ажилтан | 3 | 10 | -7 | 333.3 |
| 9002 | Гүйцэтгэх ажилтан | 206 | 199 | 7 | 96.6 |
| 9003 | Үйлчилгээний ажилтан | 36 | 36 | - | 100.0 |

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|--|----------------|----------------|-------|------|
| НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 123,790,000.00 | 123,790,000.00 | 0.00 | 0.00 |
| НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН | 123,790,000.00 | 123,790,000.00 | 0.00 | 0.00 |
| УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 119,783,180.00 | 119,783,180.00 | 0.00 | 0.00 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 114,983,180.00 | 114,983,180.00 | 0.00 | 0.00 |
| Цалин хөлс болон нэмэгдэл суутгал | 4,800,000.00 | 4,800,000.00 | 0.00 | 0.00 |
| Урамшуулал | 4,800,000.00 | 4,800,000.00 | 0.00 | 0.00 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 5,814,000.00 | 5,814,000.00 | 0.00 | 0.00 |
| Байрны түрээс | 5,814,000.00 | 5,814,000.00 | 0.00 | 0.00 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 58,569,180.00 | 58,569,180.00 | 0.00 | 0.00 |
| Багаж, техник хэрэгсэл | 58,569,180.00 | 58,569,180.00 | 0.00 | 0.00 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 28,000,000.00 | 28,000,000.00 | 0.00 | 0.00 |
| Бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 20,000,000.00 | 20,000,000.00 | 0.00 | 0.00 |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 8,000,000.00 | 8,000,000.00 | 0.00 | 0.00 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 22,600,000.00 | 22,600,000.00 | 0.00 | 0.00 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 22,600,000.00 | 22,600,000.00 | 0.00 | 0.00 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 3,586,000.00 | 3,586,000.00 | 0.00 | 0.00 |
| Бусад урсгал шилжүүлэг | 3,586,000.00 | 3,586,000.00 | 0.00 | 0.00 |
| Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 1,086,000.00 | 1,086,000.00 | 0.00 | 0.00 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,500,000.00 | 2,500,000.00 | 0.00 | 0.00 |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | 420,820.00 | 420,820.00 | 0.00 | |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 123,790,000.00 | 123,790,000.00 | 0.00 | 0.00 |
| ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 123,790,000.00 | 123,790,000.00 | 0.00 | 0.00 |
| Нэмэлт санхүүжилтийн орлого | 123,790,000.00 | 123,790,000.00 | 0.00 | 0.00 |

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо

2020.02.20

Аудитын нэр

2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код

САГ-2020/232/СТА-ТШЗ

Шалгагдсан байгууллагын нэр:

Монгол Улсын Консерватори

Мянган төгрөгөөр

| No | Алдаа зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|----|---|------------|---------------------------------------|--|------------|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| A | 3 | 4 | 5 | 8 | 9 |
| 1 | Тээвэр шатахууны нормативт зардлыг батлагдсан төсөвтэй харьцуулахад зардал 562.5 мянган төгрөг хэтэрсэн боловч тус зардлын тооцооллыг хийж батлагдсан нормативт зардлын төсөвтэй харьцуулахад хэтрээгүй байна. Харин сургуулийн аж ахуйн хэрэгцээнд бараа материал, сурагчдын сурах бичиг татан авах, хөгжим техник хэрэгсэл зөөх, оюутан, сурагчид болон багш нарыг төрийн ёслолын үйл ажиллагаа /чингис хаан одон гардуулах гэх мэт/, улсын баяр наадмын арга хэмжээ, телевиз, радиод уран бүтээлийн бичлэг хийлгэх, Монгол Улсын Засгийн газрын соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэн орон нутгийн иргэдэд урлагийн тоглолтоор үйлчлэх гэх мэт зайлшгүй ажлын шаардлага гарсан үед машин хөлслөхөд гарсан зардлаар хэтэрсэн. | 562.5 | Зөвлөмж өгсөн. | Ерөнхий нягтлан бодогч | Д.Болормаа |
| 2. | Тайлант онд 671.4 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн байна. Энэ нь татварын байгууллагад өгөх хувь хүнээс суутгасан орлогын албан татварын тооцоо болон сургуулийн үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн тооцоог хийгээгүйгээс үүссэн байна. | 671.4 | Зөвлөмж өгсөн. | Ерөнхий нягтлан бодогч | Д.Болормаа |

Монгол Улсын Консерваторийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | | | |
|---|--|----------------|----------------|------------------------|------------|
| 3 | Тус байгууллага нь БСШУСЯ-ны 2017 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/40 дүгээр тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрддөг. Энэ нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан дүрэм журам нь хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомж, стандарт, дүрэм журам, заавартай нийцэхгүй байна. | - | Зөвлөмж өгсөн. | Ерөнхий нягтлан бодогч | Д.Болормаа |
| 4 | Ординат ХХК-ийн Виница программ нь анхны өртгөө элэгдлээрээ нөхсөн зөвхөн үлдэгдэл, мэдээлэл харах зорилготой санхүүгийн программ байна. | 700.0 | Зөвлөмж өгсөн. | Ерөнхий нягтлан бодогч | Д.Болормаа |
| | | 1,933.4 | | | |